



# Киргизстан, Монгол, Тажикистан улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зайн сургалтын шинэлэг арга барил

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ “НҮҮДЛИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ” ТББ  
2021 ОНЫ 10 САРЫН 27. УЛААНБААТАР



[www.gpekix.org](http://www.gpekix.org)

## АГУУЛГА:

1. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ
2. КОВИДЫН ҮЕИЙН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХИЙСЭН ИННОВАЦИ
3. МОНГОЛ УЛСЫН ЕБС-ИЙН ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ АСУУДЛУУД
4. ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР СОНГОЛТ

# 01. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ



**839** ЕБС-н тоо



**34 073** ЕБС-н үндсэн багшийн тоо




**680.8** мянга ЕБС-н сурагчдын тоо

2020-2021 оны хичээлийн жилд:

- 839 ЕБС,
- 34073 үндсэн багш ажиллаж,
- 680.8 мянган суралцагч суралцаж байна (ҮСХ, 2021)

# 01. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ



Нийт 839 ЕБС үйл ажиллагаа явуулж байгаагийн

- 33% нь нийслэл Улаанбаатарт,
- 67% нь орон нутагт байна.
- Баруун бүс 157,
- Зүүн бүс 69,
- Төвийн бүс 159,
- Хангайн бүс 177 сургууль

## Нийт ЕБС-ийн


- 80.1 хувь нь төрийн өмчит,
- 19.9 хувь нь төрийн бус өмчит сургууль

- 8.6 хувь нь бага сургууль,
- 13.0 хувь нь дунд сургууль,
- 78.4 хувь нь ахлах сургууль



# 01. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

Ковид 19 үеийн  
боловсрол олгох үйл  
явцыг  
баримтжуулах



Хямралын нөхцөлд  
төрөөс бодлого,  
хөтөлбөр, дэмжлэг  
үзүүлэх

Боловсролд  
үзүүлсэн шууд үр  
нөлөөг судлан  
ТОГТООХ

2020 оны 11 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 178

улаанбаатар  
хот

Бүх нийтийн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3 дахь заалт, Монгол Улсын  
Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн  
26/16 дугаар зөвлөмж, Эрсдэлийн үнэлгээний 14 дүгээр зөвлөмжийг тус тус  
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж зорилгоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.
2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.9-д заасан шаардлагад нийцүүлэн холбогдох удирдамжийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд хягаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.
4. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төмөр замын дамжин өнгөрөх болон улс, хот хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хөвийн үйл ажиллагааг ариутгал халдваргүйжилтийн дэглэмийн хүрээнд зохион байгуулж явуулахыг холбогдох Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.



Боловсролын  
байгууллагуудын  
үйл ажиллагааг  
сэргээх

Зөвлөмж  
боловсруулж  
бодлого  
тодорхойлох,  
хэрэгжүүлэх

# 01. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ



- 2020-2021 онд 170 хоног хичээллэхээс 50 хоногт (30 хувь) танхимаар, 70 хувьд нь танхимын бусаар хичээллэсэн байна (БШУЯ, 2021).
- Гэр бүлийн орчинд нь техникийн нөхцөл боломж бүрдээгүйн улмаас 330 сумын 172300, 46 багийн 6277, нийт 178577 сурагч теле болон цахим сургалтад хамрагдаагүй (БШУЯ, 2021).
- 2020 оны теле хичээлд хамрагдалтын улсын дундаж 74,7% (БШУЯ, 2021).
- 2021 онд нийт сурагчдын 21% нь ямар нэг шалтгаанаар теле хичээл үзээгүй байна. (НУБХС, 2021).



# 01. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ




- 2021 оны 3 сарын 1-ний өдрөөс орон нутгийн ЕБС-ийн танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхэд 47478 хүүхэд хамрагдаагүй, 1450 суралцагч эцэг, эхийн хамт оторлож сургуулиас хөндийрсөн (*Боловсролын хүрээлэн, 2020*)
- 2021 оны 3-р сард хичээл сургалтын хоцрогдлыг 40-50%-тай гэж үзсэн байна.
- Бага ангийн унших ба математикийн чадварын үнэлгээ 27-56.5%-тай байгаа нь хоцрогдлын түвшин өндөр байгааг харуулж байна.
- Казак хүүхдийн унших чадварын гүйцэтгэл монгол хүүхдийнхээс 2 дахин доогуур, мөн математикийн чадвар доогуур байна (*Дэлхийн банк, 2020*).

# 01. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

БШУЯ,НҮБ-ын сантай хамтран хийсэн “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх” судалгаа



Бага ангийн сурагчдын 44,4%, дунд ангийн сурагчдын 10,2%, ахлах ангийн сурагчдын 17,4% нь хөдөлгөөн багассан, хөдөлгөөний дутагдал ихтэй гарсан бол, бага ангийн сурагчдын 6,7%, дунд ангийн сурагчдын 14,2%, ахлах ангийн сурагчдын 10,3% нь жин нэмсэн, дунд 30,7% болон ахлах 44,6% ангийн сурагчдын нойрны дэглэм алдагдаж, гурван хүүхэд тутмын нэгийнх нь цагийн зохицуулалт их замбараагүй болсон гэсэн үр дүн гарсан байна. /БШУЯ, НҮБ хамтарсан “Нийгэм, сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх” судалгаа /





## 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ

### Инчеоны тунхаглал 2030:

### ЭЗХАХБ-ын Ирээдүйн боловсрол ба ур чадвар–2030:



#### **>** Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024):

“Иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах”

#### **>** Алсын хараа-2050:

- Бусадтай хамтран амьрах, ажиллах чадвар бүхий иргэнийг бэлтгэх
- Боловсролын бүх шатанд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлэх г.м

#### **>** Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030):

- Судалгаанд үндэслэн бодлого төлөвлөлт, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх
- Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлэх, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгох г.м

## 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ

1. **Цахим сургалтын платформ:** Цахим контентын [www.econtent.edu.mn](http://www.econtent.edu.mn) цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэхэд НҮБ-ын нэгдсэн төслийн хүрээнд дэмжлэг үзүүлэхээр болон, БМТТ дээр платформын хөгжүүлэлтийг хийж, ЕБС-ийн сурах бичгийг цахим хувилбар руу хөрвүүлж дуусаад байна.
2. **Сургалтын удирдлагын систем:** БШУ-ны сайдын 2020оны "Туршилт зохион байгуулах тухай" А/72 дугаар тушаалын дагуу хувийн хэвшлийн боловсролын сургалтын цахим сургалтын систем хөгжүүлсэн 6 аж ахуйн нэгжтэй санамж бичиг байгуулан төрийн өмчийн аймаг нийслэлийн 108 сургуульд тухайн сургалтын системийг 10-12 сард туршилтаар нэвтрүүлэн ажиллав.
3. **Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх:** Азийн хөгжлийн банкны "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд БМД-ийн цахим сургалтын платформыг хөгжүүлэх, сургалтын материал боловсруулах, сургалт зохион байгуулах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчээр Старсофт ХХК шалгаран гэрээ байгуулаад байна.

# 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ

The screenshot shows the Medle website interface. At the top left is the logo "medle" with the tagline "mongolian education learning system". Navigation tabs include "Ерөнхий боловсрол" (highlighted), "Насан туршийн боловсрол", "Тусгай хэрэгцээт боловсрол", "Сургуулийн өмнөх боловсрол", and "Гэр бүлийн боловсрол". Below these are filters for "Анги" (Grade) and "Хичээл" (Subject). A search bar contains "Хайлт хийх ..." and a "Нэвтрэх" (Login) button. The main content area displays four educational cards:

- ЗҮГ ЧИГ**: Хүн ба орчин • 1-р анги. Зүг чиг. 5 stars (3 reviews).
- ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГСЭЛ ТАНЬЖ, ЗӨВ ХЭРЭГЛЭЖ СУРАХ**: Дүрслэх урлаг Технологи • 1-р анги. Хичээлийн хэрэгсэл таньж, зөв хэрэглэж сурах. 5 stars (2 reviews).
- ХӨГЖИЛТЭЙ АЯЛАЛ**: Хөгжим • 1-р анги. Хөгжилтэй аялал. 4 stars (4 reviews).
- АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ**: Биеийн тамир • 1-р анги. Ахуйн хэрэгцээт дасгал. 5 stars (2 reviews).

The footer section features the Medle logo and tagline on the left. The main text reads: "Энэхүү цахим хуудасны шинэчилсэн хувилбарыг НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Кариу Арга Хэмжээ, Нөхөн Сэргээх Сангийн дэмжлэгтэйгээр Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Боловсролын Мэдээллийн Технологийн Төв хөгжүүлэв. 2021 он. Нууцлалын бодлого".

**Холбоо барих**

- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Юнескогийн гудамж 16-р байрны 2 дугаар давхрын 201 тоот 7577-8081
- medle@edu.mn
- Цагийн хуваарь  
Даваа - Баасан 08:30 - 17:30  
Бямба - Ням Амарна

At the bottom, there are icons for Google Play and the App Store, and a Windows watermark that says "Activate Windows. Go to Settings to activate."



# 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ



Математик-555

Физик-134

Хими-100

Дүрслэх  
урлаг-82

- 2020-2021 онд 4800 цагийн теле хичээл

Видео хэрэгсэл

- 2019-2020 оны хичээлийн жилд Азийн банкны санхүүжилтээр



## 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ

БСШУЯ нь Монгол Улсын Засгийн Газраас баталсан "Зөв Монгол хүүхэд" үндэсний хөтөлбөрийн БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжсэн" Шинэ зууны боловсрол" төсөл



/Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө 2021-2023 /

## 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ

- БҮТ-өөс сурагчдын чанарын үнэлгээнд суурилж багшийн чадварыг үнэлэх цахим программ хангамжийг боловсруулахаар ажиллаж байна.
- Цахим хэрэглэгдэхүүн: КОВИД-19 цар тахлын үед нийт 104 интерактив, цахим контент бэлтгэн казак, тува, дохионы хэлтэй хувилбартай хийж [www.econtent.edu.mn](http://www.econtent.edu.mn) вэб хуудаст байршуулаад байна.

Багш нарт notebook өгөв 2020 он:



СӨБ-2200

ЕБС-1100

2021 оны 04 сарын 16 байдлаар эдгээр компьютерын ашиглалтын хугацаа нь дууссан, ихэнх нь эвдэрч актлагдсан байна. /Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө 2021-2023 /





## 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ



- Дээрх газруудтай хамтран “Теле хичээл”-ийг зохион байгуулж, дохионы орчуулагатайгаар, Баян-Өлгий аймагт үндэсний цөөнхийн казак, тува хэлээр болон насанд хүрэгчдэд зориулсан насан туршийн боловсролын хичээлүүдийг бэлтгэн түгээсэн байна.



- Тусгай хэрэгцээт боловсролыг теле хичээлийг /тусгай сургуулийн сурагчдад/ I-IX ангийн монгол хэл, математик, нийгэм ахуйн баримжаа хичээлүүдээр 2020.03.16-ны өдрөөс 2021.05.31-ны хооронд нийтдээ 189 удаагийн /4725 минут/-ын хичээл Сүлд ТВ-ээр орон даяар нэвтрүүлжээ. /Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө 2021-2023 /

# 02. КОВИДЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН СИСТЕМД ГАРСАН ИННОВАЦИ

2019-2021 оны хичээлийн жилд

640499 нийт суралцагч



Хөгжлийн бэрхшээлтэй

4302 суралцагч

86%-90%



*Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө 2021-2023*

# 03. ЕБС-ИЙН ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) – МОНГОЛ УЛС. ОЛОН ҮЗҮҮЛЭЛТИЙН БҮЛГИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА (2021.01.19) <https://www.1212.mn/surveymn.aspx>

ТВ/Радио хичээлийн хүртээмж, интернет холболтын үр дүнг тодруулахад:

- Хотоос хөдөөгийн хүртээмжийн үзүүлэлт 99

Зураг 3. ТВ/Радио хичээлийн хүртээмж



Зураг 4. Интернет холболтын хувь



Интернет холболтын хувь:

- Улсын хэмжээнд 72%
- Хөдөөд 56%,
- Хотод 78% байсан.

- Суралцагчдын 98% нь телевизээр хичээлд хамрагдсан.
- Сургалтын материалын хүртээмж 33%, зайн сургалтын сэтгэл ханамж 37%-тай гарсан





## 03. ЕБС-ИЙН ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД



- Багш нарын “цахим хичээл бэлтгэх”-тэй холбоотой гарын авлага, сургалтын материал, арга зүйн сургалт, цахим хичээлийн талаар зааварчилгаа авсан гэх үзүүлэлт 20% байсан.
- Оролцогчдын 41.3% хувь нь цахим зайны сургалтын материалыг шинээр бэлдсэн.
- Судалгаанд хамрагдсан багш нарын 80 орчим хувь нь гэрээс ажиллахад хүндрэлтэй байсан. /ИНБ-аас хийсэн “Ковид-19 цар тахлын шалтгаант багшлахуй, суралцахуй”, судалгааны тайлан/

# 03. ЕБС-ИЙН ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

- Багш нар ажил үүргээ гүйцэтгэхийн тулд нэг удаад компьютер ухаалаг утас, чихэвч, камер микрофон, интернэт суурилуулах зэрэг 100000-2000000 төгрөг зарцуулсан.
- Утас дата, цахилгааны төлбөрт сар бүр дунджаар 30000-40000 төгрөг зарцуулсан.
- Зөөврийн компьютер, ухаалаг утасыг лизингээр авсан байна. /ИНБ-аас хийсэн "Ковид-19 цар тахлын шалтгаант багшлахуй, суралцахуй", судалгааны тайлан /




# 03. ЕБС-ИЙН ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД



10%-15% интернетийн сүлжээгүй

- Нийт өрхийн 35.3% нь интернетэд холбогдсон байдаг боловч орон нутагт энэ үзүүлэлт 0.08%-тай,
- Улаанбаатар хотын 387453 өрхийн 47.9% нь гэртээ компьютергүй байна.
- Салбарын яам болон бусад байгууллагуудын хийсэн судалгааны дүнгээс харахад боловсролын бүх шатанд суралцагчдын 20.0 орчим хувь нь теле болон цахим сургалтанд хамрагдаагүй. /НҮБ-ийн хүүхдийн сан/.






## 03. ЕБС-ИЙН ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД



- Эцэг эх хүүхэддээ зарцуулах цаг, боломж, чадвар хангалтгүй байсан гэж судалгаанд хамрагдсан багш нарын 80-90 хувь нь үзсэн. (ИНБ, 2020)
- Багш нараас авсан судалгаанд эцэг эхчүүдийн 45.3% нь хүүхэддээ бага зэрэг тусласан, 12% нь огт туслаагүй. (ИНБ, 2020)
- Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 89% нь мэдээллийн сувгаас нэг техник хэрэгсэл ашиглах чадвартай, үлдсэн нь ашиглах чадваргүй. (НҮБХС, 2020)



## 03. ЕБС-ИЙН ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД



Ковид-19 цар тахлын улмаас сургууль цэцэрлэгийг түр хааснаас үүдэн:

- хүүхэд гэртээ хараа хяналтгүй үлдэх,
- хүүхэд асрах, харах үйлчилгээ байхгүй,
- гэртээ боловсролын үйлчилгээнд хамрагдах үед туслах, хяналт тавих дэмжлэггүй,
- гэр бүлийн таагүй орчинд олон цагаар байх, хоол хүнсний хэрэглээ тасрах,
- дунд, ахлах ангийн хөвгүүд хөдөлмөр эрхлэх
- хүүхдийн эрх хамгаалалд сөрөг үр дагаварууд бүхий бусад хүчирхийллүүд нэмэгдсэн. /ИНБ-ын Онцгой үеийн теле хичээл, түүний үр дүн, тохиромжтой байдал. Судалгааны тайлан 2020/


# 04. ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР СОНГОЛТ



СУРАЛЦАГЧ



БАГШ



ЭЦЭГ ЭХ, АСРАН  
ХАМГААЛАГЧ



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

МЭРГЭЖЛИЙН  
ХҮМҮҮС

# 04. ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТҮҮВЭР СОНГОЛТ



- Баруун бүс- Ховд аймаг – **15.1%**
- Зүүн бүс- Дорнод аймаг – **13.4%**
- Говийн бүс- Өмнөговь аймаг -**11.2%**
- Төвийн бүс- Баянзүрх дүүрэг – **60.3%**

**Харьцаа – (60:40)**

**Нийт - 537619**

**1-9 ангид - 103159**

**Багш – 6484**

Эх сурвалж: БШУЯ, 2021





**БАЯРЛАЛАА**